



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

22 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 496

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 37,900,000.00 (гучин долоон сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 8,422,222.24 (найман сая дөрвөн зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Э.Галбадрах, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Билэгтсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001609

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 11-дүгээр сарын 11-ний өдрийн  
496 дугаар тогтоолын хавсралт



Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй Халдварт өвчин судлалын үндэсний  
төвд балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр                                             | Ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)                                   | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                             | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг)                                                                                                                |
|-----|-----------------------------------------------------------|------------------------|------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | УАЗ-220695-550, 27-54<br>УАН, арал №<br>ХТТ220695L1213061 | 2019/<br>2020          | 37,900,000.00                                              | 8,422,222.24                                                                                                                  | 29,477,777.76                                                                                                                             |
|     | Нийт дүн                                                  |                        | 37,900,000.00<br>/гучин долоон<br>сая есөн зуун<br>мянган/ | 8,422,222.24<br>/найман сая<br>дөрвөн зуун<br>хорин хоёр<br>мянга хоёр<br>зуун хорин<br>хоёр төгрөг<br>хорин дөрвөн<br>мөнгө/ | 29,477,777.76<br>(хорин есөн сая<br>дөрвөн зуун<br>далан долоон<br>мянга долоон<br>зуун далан<br>долоон төгрөг<br>далан зургаан<br>мөнгө) |